

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2013 оны 10 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

### "ЧИНГИС ХААН" ОДОНД НЭР ДЭВШҮҮЛЭХ, ШАГНАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2002 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 21 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

- 1."Чингис хаан" одонд нэр дэвшүүлэх, шагнах журмыг хавсралтаар баталсугай.
- 2.Энэ журмын талаар олон нийтэд мэдээлэхийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар /П.Цагаан/-т үүрэг болгосугай.

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Ц.ЭЛБЭГДОРЖ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 55 дугаар зарлиг, 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Журамд өөрчлөлт оруулах тухай 190 дүгээр зарлигаар орсон өөрчлөлтийг тус тус тусгав/